



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/46

Төмөрбулаг сум

**Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь хэсэг Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4.3, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн эзэмшлийн талбай, Жаргалант, Бүгсийн гол дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 27-наас 28- ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сумын нэгдсэн цэвэрлэгээг хийх ажлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, ажлын зардал төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Нийтийн эзэмшлийн талбай цэвэрлэж байгаа ААН байгуулагууд машин болон шатахууныхаа хэрэгцээг гаргаж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Өөрийн хариуцсан талбайн хог хаягдлыг цэвэрлүүлэх, цэвэрлэсэн газраа 5 дугаар багийн даргад хүлээлгэж өгөхийг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5.Нийтийн цэвэрлэгээний ажлыг хангалтгүй зохион байгуулсан байгууллагын дарга нар, цэвэрлэгээнд гарч ажиллаагүй албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцохыг сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч Ц.Баярцэнгэл , БОХУ-ын байцаагч Д.Хишигсайхан, 5 дугаар багийн засаг дарга Ш.Нацагдорж нарт даалгасугай.

11 дугаар ангийн
Сурагчид бүх
төрийн
байгууллагууд

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ